БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Бугат сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код: БӨА-2024/191/НА-СТА-ТШЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Өлгий хот<br>2023 он | Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ж.Айгүл<br>Утас: 70422954 Цахим хаяг: aigulj@audit.gov.mn<br>Аудитын менежер: Х.Женисбек<br>Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn<br>Ахлах аудитор: Ж.Назгүл<br>Утас: 88403281 Цахим хаяг: nazgulj@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**АГУУЛГА**


**1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ** ..... 3

**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ** ..... 5

**3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА** ..... 12

**4. АУДИТЫН ТАЙЛАН** ..... 15

**4.1 Ерөнхий зүйл** ..... 15

**4.2 Материаллаг байдал** ..... 16

**4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт** ..... 16

**4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал** ..... 16

**4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт** ..... 16

**4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт** ..... 17

**4.5.1 Завсрын аудитын талаар** ..... 17

**4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал** ..... 17

**5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ** ..... 17

**5.1 Төлбөрийн акт** ..... 17

**5.2 Албан шаардлага** ..... 18

**5.3 Зөвлөмж** ..... 18

**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ** ..... 18


**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын стандарт |
| ШЕЗ | Шүүхийн ерөнхий зөвлөл |
| ТТӨХ | Тоног төхөөрөмж |

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgii@audit.gov.mn

БУГАТ СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН
ТӨВИЙН ДАРГА О.СЕРИКЖАН
ТАНАА

2024.02.14. № 92
танай ____________ -ны № ____________ -т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Бугат сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бугат сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Аудитын гол асуудал**

Тайлант онд аймгийн Эрүүл мэндийн газраас 2022 оны санхүүгийн баримт болон үйл ажиллагаанд хяналт үнэлгээ хийж зөвлөмж өгч ажилласан байна.

Материаллаг буруу эрсдэлийн үнэлгээ өндөр анхаарал татах асуудал гараагүй болно.

**Бусад асуудлын хэсэг**

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

004021..5

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ж.АЙГҮЛ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

**Төгрөгөөр**

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **99,119,287.99** | **110,852,014.86** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 27,090,820.50 | 20,255,184.77 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | 27,090,820.50 | 20,255,184.77 |
| **3121** | **Төгрөг** | 27,090,820.50 | 20,255,184.77 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 27,090,820.50 | 20,255,184.77 |
| **33** | **АВЛАГА** | 6,545,260.03 | 25,522,180.12 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 6,479,160.03 | 10,788,442.12 |
| 33200 | Төлбөртэй үйлчилгээний авлага | | 14,733,738.00 |
| 33300 | Татаас, санхүүжилтийн авлага | 66,100.00 | |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 65,483,207.46 | 65,074,649.97 |
| **351** | **Түүхий эд материал** | 56,456,349.76 | 58,253,745.71 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | - | - |
| 35130 | Эм боох материал | 56,456,349.76 | 58,253,745.71 |
| 35200 | Дуусаагүй үйлдвэрлэл | - | - |
| 35300 | Бэлэн бүтээгдэхүүн | - | - |
| **354** | **Хангамжийн материал** | 9,026,857.70 | 6,820,904.26 |
| 35410 | Бичиг хэргийн материал | - | - |
| 35420 | Аж ахуйн материал | 9,026,857.70 | 6,820,904.26 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **485,805,343.20** | **475,407,048.31** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 485,805,343.20 | 475,407,048.31 |
| 391 | Газар | - | - |
| **392** | **Биет хөрөнгө** | 479,213,343.20 | 468,815,048.31 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 435,785,201.92 | 435,785,201.92 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (62,498,672.68) | (78,170,101.24) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 83,519,172.00 | 86,519,172.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (46,553,675.68) | (56,044,592.60) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 98,872,904.68 | 121,978,790.88 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (30,263,614.24) | (47,388,143.05) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 33,011,955.00 | 38,768,883.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (32,850,427.80) | (32,824,662.60) |
| 39217 | Ном | 190,500.00 | 190,500.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 6,592,000.00 | 6,592,000.00 |
| 39301 | Програм хангамж | 550,000.00 | 550,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (550,000.00) | (550,000.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | - | - |
| 39304 | Хуримтлагдсан элэгдэл | 6,592,000.00 | 6,592,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **584,924,631.19** | **586,259,063.17** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **-** | **-** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **584,924,631.19** | **586,259,063.17** |

| | | | |
|---|---|---|---|
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 584,924,631.19 | 586,259,063.17 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 466,568,107.00 | 466,568,107.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 466,568,107.00 | 466,568,107.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 95,584,605.55 | 96,919,037.53 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 95,584,605.55 | 95,584,605.55 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | 1,334,431.98 |
| 51230 | Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс | - | - |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 22,771,918.64 | 22,771,918.64 |
| 51400 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | - | - |
| 51500 | Бодлогын өөрчлөлт алдааны залруулга | - | - |
| 51600 | Нөөцийн сан | - | - |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **584,924,631.19** | **586,259,063.17** |

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

**Төгрөгөөр**

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **721,726,903.95** | **800,848,384.30** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **86,429,583.95** | **29,211,476.20** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 86,429,583.95 | 29,211,476.20 |
| 120004 | Төсөвт байгууллагын өөрийн орлого | 86,429,583.95 | |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 86,429,583.95 | |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө | - | 23,363,236.20 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал | - | 5,848,240.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **635,297,320.00** | **771,636,908.10** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 300,000.00 | |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 300,000.00 | |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 31,856,000.00 | 34,687,000.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 31,856,000.00 | 34,687,000.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 603,141,320.00 | 736,949,908.10 |
| 134001 | Нийгмийн даатгалын сангаас санхүүжих | - | - |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 603,141,320.00 | 736,949,908.10 |
| 134003 | Нийгмийн даатгалын сангаас эмнэлгүүдэд олгох санхүүжилт | - | - |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **508,055,298.69** | **799,513,952.32** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **508,055,298.69** | **799,513,952.32** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 508,055,298.69 | 799,513,952.32 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 346,258,828.53 | 507,450,972.00 |
| 210101 | Үндсэн цалин | 154,974,871.65 | 507,450,972.00 |
| 210102 | Нэмэгдэл | 152,494,407.53 | |

| | | | |
|---|---|---|---|
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 1,499,153.00 | |
| 210104 | Урамшуулал | 37,290,396.35 | |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 94,258,469.66 | 67,053,517.91 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 63,362,085.75 | 67,053,517.91 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 6,826,117.00 | |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 6,974,110.95 | |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 9,562,874.58 | |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 7,533,281.38 | |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 28,947,000.00 | 31,833,000.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,969,400.00 | 2,788,000.00 |
| 210302 | Түлш, халаалт | 26,977,600.00 | 29,045,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 8,351,900.00 | 47,273,098.55 |
| 210401 | Бичиг хэрэг | 919,100.00 | 8,471,040.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 7,379,700.00 | 23,711,572.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 53,100.00 | 2,257,400.00 |
| 210404 | Ном, хэвлэл | - | - |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | - | 1,530,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | - | 11,303,086.55 |
| **2105** | **Нормативт зардал** | 8,825,038.50 | 84,897,376.77 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 5,222,638.50 | 69,868,736.77 |
| 210502 | Хоол, хүнс | 2,856,400.00 | 8,556,690.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 746,000.00 | 6,471,950.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 2,280,700.00 | 2,056,156.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 931,700.00 | 490,656.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,349,000.00 | 1,565,500.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 224,000.00 | 1,625,500.00 |
| 210701 | Гадаад албан томилолт | - | |
| 210702 | Дотоод албан томилолт | 224,000.00 | 1,625,500.00 |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | - | |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 249,900.00 | 1,370,500.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | - | 39,500.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | - | - |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 249,900.00 | 1,331,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 18,659,462.00 | 55,953,831.09 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,070,000.00 | 12,432,300.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | - | - |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 17,589,462.00 | 43,521,531.09 |
| 210904 | Найдваргүй авлагын алдагдал | - | |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **213,671,605.26** | **1,334,431.98** |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | - | - |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **213,671,605.26** | **1,334,431.98** |

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

**Төгрөгөөр**

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **641,877,720.00** | **756,969,270.10** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **641,877,720.00** | **756,969,270.10** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 300,000.00 | - |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 300,000.00 | |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 31,856,000.00 | 34,687,000.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 31,856,000.00 | 34,687,000.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 609,721,720.00 | 722,282,270.10 |
| 134001 | Нийгмийн даатгалын сангаас санхүүжих | | |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 609,721,720.00 | 722,282,270.10 |
| 134003 | Нийгмийн даатгалын сангаас эмнэлгүүдэд олгох санхүүжилт | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **613,786,900.00** | **754,044,905.83** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **613,786,900.00** | **754,044,905.83** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **613,786,900.00** | **754,044,905.83** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 395,394,200.00 | 506,465,041.28 |
| 210101 | Үндсэн цалин | 259,428,447.55 | 293,651,581.85 |
| 210102 | Нэмэгдэл | 90,068,252.45 | 152,168,898.31 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 6,401,200.00 | 6,729,000.00 |
| 210104 | Урамшуулал | 39,496,300.00 | 53,915,561.12 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | | |
| 210106 | Ажиллагчдад төлсөн /ТӨҮГ/ | | |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 51,303,300.00 | 71,362,800.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 34,992,900.00 | 48,527,100.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,077,600.00 | 5,709,200.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,262,100.00 | 4,566,900.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 815,500.00 | 1,141,700.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 8,155,200.00 | 11,417,900.00 |
| 210206 | Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/ | | |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 29,002,000.00 | 31,833,000.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,024,400.00 | 2,788,000.00 |
| 210302 | Түлш, халаалт | 26,977,600.00 | 29,045,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 28,138,200.00 | 33,867,398.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 4,983,600.00 | 5,687,700.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 19,810,100.00 | 20,534,198.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,900,000.00 | 2,158,100.00 |
| 210404 | Ном, хэвлэл | | |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,444,500.00 | 1,487,400.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | | 4,000,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 75,104,900.00 | 86,649,966.55 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 60,047,900.00 | 67,793,746.55 |
| 210502 | Хоол, хүнс | 8,150,400.00 | 10,811,600.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 6,906,600.00 | 8,044,620.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 10,371,800.00 | 7,907,800.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 7,117,700.00 | 2,206,300.00 |
| 210602 | Тавилга | | |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | | |
| 210604 | Урсгал засвар | 3,254,100.00 | 5,701,500.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 833,700.00 | 1,647,500.00 |
| 210701 | Гадаад албан томилолт | | |
| 210702 | Дотоод албан томилолт | 833,700.00 | 1,647,500.00 |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | | |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 957,500.00 | 1,879,100.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | | |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 360,000.00 | |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 30,000.00 | |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 45,000.00 | 39,500.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 33,000.00 | 33,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 450,000.00 | 1,430,300.00 |
| 210807 | Газрын төлбөр | 39,500.00 | |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | | |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | | 376,300.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 22,681,300.00 | 12,432,300.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 22,681,300.00 | 12,432,300.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **28,090,820.00** | **2,924,364.27** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **1,000,000.00** | **9,760,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **1,000,000.00** | **9,760,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 1,000,000.00 | 9,760,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 1,000,000.00 | 9,760,000.00 |
| **2260** | **Гадаад эх үүсвэрээр** | - | - |
| 226001 | Гадаад эх үүсвэрээр | | |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(1,000,000.00)** | **(9,760,000.00)** |
| | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **7** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | - | - |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 27,090,820.00 | (6,835,635.73) |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 0.50 | 27,090,820.50 |

| | | | |
|---|---|---|---|
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 27,090,820.50 | 20,255,184.77 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

**Төгрөгөөр**

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| C01 | **2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | 466,568,107.00 | 22,771,918.64 | 95,584,605.55 | | 584,924,631.19 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | | - |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **466,568,107.00** | **22,771,918.64** | **95,584,605.55** | - | 584,924,631.19 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | | | | | - |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | | | | | - |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | | | | | - |
| C07 | Тайлант үеийн үр дүн | | | | | - |
| C08 | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **466,568,107.00** | **22,771,918.64** | **95,584,605.55** | - | 584,924,631.19 |
| D01 | **2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **466,568,107.00** | **22,771,918.64** | **95,584,605.55** | - | 584,924,631.19 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | | - |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **466,568,107.00** | **22,771,918.64** | **95,584,605.55** | - | 584,924,631.19 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | | | | | - |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | | | | | - |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | | | | | - |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | | | | | - |
| D08 | Тайлант үеийн үр дүн | | | 1,334,431.98 | | 1,334,431.98 |
| D09 | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **466,568,107.00** | **22,771,918.64** | **96,919,037.53** | - | 586,259,063.17 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

**Төгрөгөөр**

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **784,590,300.00** | **763,804,905.83** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **784,590,300.00** | **763,804,905.83** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 784,590,300.00 | 763,804,905.83 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 541,983,400.00 | 506,465,041.28 |
| 210101 | Үндсэн цалин | 319,064,000.00 | 293,651,581.85 |
| 210102 | Нэмэгдэл | 157,111,900.00 | 152,168,898.31 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 6,138,000.00 | 6,729,000.00 |
| 210104 | Урамшуулал | 59,669,500.00 | 53,915,561.12 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | | |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 71,362,800.00 | 71,362,800.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 48,527,100.00 | 48,527,100.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 5,709,200.00 | 5,709,200.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,566,900.00 | 4,566,900.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,141,700.00 | 1,141,700.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 11,417,900.00 | 11,417,900.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 31,833,000.00 | 31,833,000.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,788,000.00 | 2,788,000.00 |
| 210302 | Түлш, халаалт | 29,045,000.00 | 29,045,000.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | | |
| 210304 | Байрны түрээс | | |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 31,174,800.00 | 34,017,398.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 5,337,700.00 | 5,837,700.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 18,547,500.00 | 20,534,198.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,802,200.00 | 2,158,100.00 |
| 210404 | Ном, хэвлэл | | |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,487,400.00 | 1,487,400.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 4,000,000.00 | 4,000,000.00 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | | |
| **2105** | **Нормативт зардал** | 77,458,500.00 | 86,649,966.55 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 60,071,900.00 | 67,793,746.55 |
| 210502 | Хоол, хүнс | 9,811,600.00 | 10,811,600.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 7,575,000.00 | 8,044,620.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 13,371,000.00 | 17,463,800.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 7,712,000.00 | 11,762,300.00 |
| 210602 | Тавилга | | |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | | |
| 210604 | Урсгал засвар | 5,659,000.00 | 5,701,500.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 2,765,500.00 | 1,647,500.00 |
| 210701 | Гадаад албан томилолт | | |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,765,500.00 | 1,647,500.00 |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | | |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 2,155,000.00 | 1,879,100.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 30,000.00 | |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 45,000.00 | 39,500.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 33,000.00 | 33,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,631,200.00 | 1,430,300.00 |
| 210807 | Газрын төлбөр | 39,500.00 | |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 376,300.00 | 376,300.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 12,486,300.00 | 12,486,300.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 12,486,300.00 | 12,486,300.00 |
| **13** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **784,590,300.00** | **756,969,270.10** |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 34,687,000.00 | 34,687,000.00 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 34,687,000.00 | 34,687,000.00 |
| 132007 | Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих | | |
| **1340** | **НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 749,903,300.00 | 722,282,270.10 |

| | | | |
|---|---|---|---|
| 134001 | Нийгмийн даатгалын сангаас санхүүжих | | |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 749,903,300.00 | 722,282,270.10 |
| 134003 | Нийгмийн даатгалын сангаас эмнэлгүүдэд олгох санхүүжилт | | |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | 27,090,820.50 |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | 20,255,184.77 |
| **6** | **ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ** | | |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | 1 | 1 |
| 610001 | Төсвийн байгууллага | 1 | 1 |
| 610002 | Төсвөөс гадуур байгууллага | | |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 31.00 | 31.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 1.00 | 1.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 27.00 | 25.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 3.00 | 5.00 |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **31.00** | **30.00** |
| 650008 | Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ) | 25.00 | 22.00 |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 6.00 | 8.00 |

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

**Төгрөгөөр**

Нэмэлт санхүүжилт аваагүй

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар

Бугат сумын Эрүүл мэндийн төв нь эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ үзүүлэх чиг үүрэгтэй чиг үүргийг хэрэгжүүлдэг байгууллага.

Байгууллагын удирдлагын тогтолцоо менежментийг боловсронгуй болгох, байгууллагын хөгжлийг сайжруулах, хүний нөөцийн төлөвлөлт, сонгон шалгаруулалт, сургалтыг сайжруулах, чадавхжуулах, оношилгоо, эмчилгээнд орчин үеийн мэдээлэл, технологийг нэвтрүүлсэн цахим эмнэлэг болох, дэд бүтэц, дотоод, гадаад орчны тохижилтыг сайжруулах, төсөв санхүү, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, хангалтын нөөц, чадавхыг нэмэгдүүлэх, хариуцлага, хяналтын тогтолцоог боловсронгуй болгох гэсэн зорилт дэвшүүлэн ажилласан байна.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар

Бугат сумын Эрүүл мэндийн төв нь Монгол Улсын үндсэн хууль, Монгол Улсын Эрүүл мэндийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль,

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон бусад хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Бугат сумын Эрүүл мэндийн төвд 2023 онд аймгийн Эрүүл мэндийн газраас үйл ажиллагааны болон 2022 оны санхүүгийн баримтад шалгалт орж зөвлөмж өгч ажилласан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт *үр нөлөөтэй* байна.

Дотоод аудит/аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах /дотоод аудитораас шууд туслалцаа авах *шаардлагагүй* гэж үзлээ.

**3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Бугат сумын Эрүүл мэндийн төв нь 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Сангийн сайдын 2023 оны 65 дугаар “Хөтөлбөр батлах тухай” тушаалаар аккруэл суурьт УСНББОУС-ыг нэвтрүүлэх дунд хугацааны хөтөлбөрийг баталсан байна.

**Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар**

Байгууллагын даргын 2023 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн Б/18 тоот тушаалаар баталсан Нягтлан бодох бодлогын баримт бичгийг мөрдөж ажилласан байна.

**3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

Бугат сумын Эрүүл мэндийн төв нь 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна. Байгууллагын хөтөлбөл зохих нягтлан бодох бүртгэлийг холбогдох заавар журмын дагуу

хөтөлж, бараа материалын тайланг гаргаж, цалингийн цэсэд хавсаргах холбогдох тушаал, шийдвэр болон санхүүгийн анхан шатны баримтуудыг зохих журмаар бүрдүүлсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 16.6 сая төгрөгөөр буюу 2.8 хувиар буурсан байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 27,090.80 | 20,255.20 | -6,835.60 |
| Авлага | 6,545.30 | 25,522.20 | 18,976.90 |
| Бараа материал | 65,483.20 | 47,139.80 | -18,343.40 |
| Үндсэн хөрөнгө | 485,805.30 | 475,407.00 | -10,398.30 |
| **Нийт хөрөнгө** | **584,924.60** | **568,324.20** | **-16,600.40** |
| Өр төлбөр | | | |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 584,924.60 | 568,324.20 | -16,600.40 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **584,924.60** | **568,324.20** | **-16,600.40** |

Мөнгөн хөрөнгийн данс 20.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарч өмнөх оноос 6.8 сая төгрөгөөр буурсан нь цалингийн зардлаас үүссэн хэмнэлттэй холбоотой байна.

Авлагын дансны үлдэгдэл өмнөх оноос 18.9 сая төгрөгөөр нэмэгдсэн нь татаас санхүүжилтийн авлага 14.7 сая төгрөг, ажилчдын НДШ-ийн авлага 5.4 сая төгрөг, ХХОАТ-ын авлага 5.3 сая төгрөгийн авлага үүссэнтэй холбоотой байна.

Бараа материалын данс 18.3 сая төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 143.9 сая төгрөгийн бараа материалыг худалдан авч, Эрүүл мэндийн газраас 4.3 сая төгрөгийн, Эрүүл мэндийн яамнаас 1.5 сая төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгслийг үнэгүй хүлээн авч, үйл ажиллагаанд 168.1 сая төгрөгийн бараа материалыг зарцуулсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн данс 10.4 сая төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 9.8 сая төгрөгийн хөрөнгө худалдан авч аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөс 3.0 сая төгрөгийн багийн эмчийн мотоцикл, Эрүүл мэндийн сайдын А/85 тушаалаар 9.2 сая төгрөгийн, А/246 тушаалаар 1.6 сая төгрөгийн, А/248 тоот тушаалаар 5.4 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг, аймгийн Эрүүл мэндийн газраас 4.2 сая төгрөгийн тавилга, эд хогшлыг үнэгүй хүлээн авсан байна. Бугат сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2024 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн 07 дугаар хуралдааны тогтоолоор 0.5 сая төгрөгийн тоног төхөөрөмж, 0.7 сая төгрөгийн тавилга хэрэгслийг акталж данс бүртгэлээс хассан байна.

Тайлант оны үр дүнгээр Засгийн газрын хувь оролцоо данс 16.6 сая төгрөгөөр буурсан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Эрүүл мэндийн даатгалын сангаас гүйцэтгэлээр санхүүждэг байгууллага байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл.

Эрүүл мэндийн төвийн 2023 оны төсвийн хэлбэлзлийн тайлангаар зарцуулах төсөв нь 811.7 сая төгрөг байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 777.0 сая төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас, 34.7 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс бүрдүүлэхээр тусгасан байна.

Гүйцэтгэлээр Эрүүл мэндийн даатгалын сангаас 722.3 сая төгрөгийн санхүүжилт авч, орон нутгийн төсвөөс 34.7 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 756.9 сая төгрөг буюу 96.5 хувьтай буюу дансанд 20.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1 | Нэг иргэнд ногдох нормативаар | 559,097.5 | 549,279.5 | 9,818.0 | 98.2 |
| 2 | Үндсэн мэргэжлийн тусламж үйлчилгээ | 190,805.8 | 173,002.8 | 17,803.0 | 90.7 |
| 3 | Төрийн өмчийн барилгын тогтмол зардал | 34,687.0 | 34,687.0 | - | 100.0 |
| | **Дүн** | **784,590.3** | **756,969.3** | **27,621.0** | 96.5 |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Тайлант онд нэмэлт санхүүжилт аваагүй байна.

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Бугат сумын Эрүүл мэндийн төв нь 2023 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

### 3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Бугат сумын Эрүүл мэндийн төв нь 2023 онд батлагдсан төсвийн хүрээнд 143.9 сая төгрөгийн бараа материал, 9.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Бугат сумын Эрүүл мэндийн төв нь 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Назгүл гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор Ж.Айгүл нар тус тус хэрэгжүүлсэн.

Бугат сумын Эрүүл мэндийн төв 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 09 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

**4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 627.6 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 9.4 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэх шатанд материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагын 817.4 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 12.3 сая төгрөгөөр шинэчлэн тогтоов.

**4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад хуулийн хэрэгжилтийг хангаж ажилласан бөгөөд алдаа, зөрчил илрээгүй.

**4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

**4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны мэдээллээс санхүүгийн тайлангийн аудитын программд орсон мэдээллийн хэрэгжилтийг шалгасан.

Шилэн дансанд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын нийтдээ 757.0 сая төгрөгийн 12 мөнгөн гүйлгээ, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 95.2 сая төгрөгийн 14 мөнгөн гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн 51.2 сая төгрөгийн 19 мөнгөн гүйлгээг бүрэн мэдээлсэн байна. Шилэн дансанд мэдээлсэн байдлын хэрэгжилтийн хувь 100 хувьтай байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн аудитаар алдаа, зөрчил илрээгүй тул нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар эхний хагас жилийн баримтыг хүлээн авч түүвэр сорил хийсэн бөгөөд алдаа зөрчил илрээгүй болно.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар 50.1 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 1 зөвлөмж өгсөн. Аудитын шийдвэрийн хэрэгжилтийг давтан шалгаж үзэхэд зөрчлийг бүрэн арилгаж ажилласан байна.

*Хүснэгт 4 Төлбөрийн акт,* албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | | | | | 100 |
| Албан шаардлага | 2 | 50145.9 | 2 | 50145.9 | 100 |
| Зөвлөмж | 1 | | 1 | | 100 |
| **Нийт дүн** | **3** | **50145.9** | **3** | **50145.9** | **100** |

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах зүйл байхгүй.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Санхүүгийн тайланд нийт 125.7 сая төгрөгийн залруулга хийгдсэн болно. Үүнд:

1. Санхүүгийн үр дүнгийн тайлангаар цалингийн зардлыг 56.6 сая төгрөгөөр, БҮТЭЗ-ийн зардлыг 8.5 сая төгрөгөөр, үнэ төлбөргүй гарсан зардлыг 3.7 сая төгрөгөөр илүү, НДШ-ийг 38.9 сая төгрөгөөр, БҮТЭЗ-ийг 1.2 сая төгрөгөөр, эм бэлдмэлийн зардлыг 18.1 сая төгрөгөөр, урсгал засварын зардлыг 3.2 сая төгрөгөөр дутуу буюу нийт 68.8 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасныг залруулсан.
2. Мөнгөн гүйлгээний тайлангийн нийт цэвэр мөнгөн гүйлгээний дүнг 0.2 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасныг залруулсан.
3. Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн төлөвлөгөөний нийт зарлага ба цэвэр зээлийн үлдэгдлийн дүнг 27.1 сая төгрөгөөр, гүйцэтгэлийг 11.4 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасныг залруулсан.
4. Байгууллагын данс бүртгэлд бүртгэлтэй хугацаа дууссан 17.9 сая төгрөгийн эмийг байгууллагын өмч хамгаалах зөвлөлийн шийдвэргүйгээр, зарлагын падаанаар акталсныг залруулав.

Аудитаар нийт 36.0 сая төгрөгийн зөрчил илэрснээс 36.0 сая төгрөгийн 2 албан шаардлага өгсөн.

### 5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогоогүй.

### 5.2 Албан шаардлага

Аудитын дүнгээр дараах зөрчилд албан шаардлага хүргүүлсэн. Үүнд:

1. 2022 оны санхүүгийн тайлангаар татвар, нийгмийн даатгалын шимтгэлд 6.5 сая төгрөгийг илүү шилжүүлж үүсгэсэн авлагыг тооцоо нийлж барагдуулаагүй, авлагыг 2023 оны эцэст 4.3 сая төгрөгөөр нэмэгдүүлж 10.8 сая төгрөгийн авлагатай гарсан, худалдан авсан эм, эмнэлгийн хэрэгсэл, хоол хүнсний бараа материалыг зохих журмын дагуу тооцоо нийлж бүртгээгүйгээс нийт дүнгээр 14.4 сая төгрөгийн өр, авлагын тооцоо нийлж баталгаажуулаагүй, санхүүгийн тайланд тусгаж тайлагнаагүй.

2. Тайлант онд зарцуулсан 21.6 сая төгрөгийн тээвэр шатахууны зардлыг шатахууны виза картанд шилжүүлэн зарцуулсан ба анхан шатны баримтыг зохих журмаар бүрдүүлээгүй, санхүүгийн программ болон санхүүгийн тайланд шилжүүлсэн мөнгөний нийт дүнгээр орлого авч, зарлага гаргасан.

Энэ нь *Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т ”* 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, 26 дугаар зүйлийн 26.2-т ”26.1.Төсвийн байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу бүрэн аккруэл суурьтай нягтлан бодох бүртгэл хөтөлнө”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4-т “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.2-т “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага”, 14.4.3-т “бүх өр төлбөр”, 20.2-т “Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ”, 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэж заасныг зөрчсөн байна.

<u>Шийдвэрлэсэн нь</u>: Зөрчил арилгуулах албан шаардлага өгөв.

### 5.3 Зөвлөмж

Аудитаар зөвлөмж өгөгдөөгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Санхүүгийн үр дүнгийн тайланг зөрүүтэй тайлагнасан | 1 | 68 857.4 | | | 1 | 68 857.4 | | | | | | |
| Мөнгөн гүйлгээний тайлангийн цэвэр мөнгөн гүйлгээг зөрүүтэй тайлагнасан | 1 | 204.0 | | | 1 | 204.0 | | | | | | |
| Төсвийн гүйцэтгэлийн | 1 | 38,691.3 | | | 1 | 38,691.3 | | | | | | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| тайлангийн гүйцэтгэлийг зөрүүтэй тайлагнасан | | | | | | | | | | | | |
| Өмч хамгаалах зөвлөлийн шийдвэргүйгээр эм актalsныг залруулав | 1 | 17,934.8 | | | 1 | 17,934.8 | | | | | | |
| **Дүн** | **4** | **125,687.5** | | | **4** | **125,687.5** | | | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Өр, авлагын тооцоог зөрүүтэй тайлагнасан | 1 | 14,445.7 | | | 1 | 14,445.7 | | | | | | |
| Тээвэр шатахууны зардлыг зарцуулалтыг зохих журмаар бүртгэж, тайлагнаагүй | 1 | 21,599.8 | | | 1 | 21,599.8 | | | | | | |
| **Дүн** | **2** | **36,045.5** | | | **2** | **36,045.5** | | | | | | |

## Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | |
| Төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | |
| **Нийт дүн** | | | | | | | | |